Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн
хуралдааны 2026 оны 10 дугаар сарын 19-ний
өдрийн 75 дугаар тогтоолын хавсралт

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ САНАЛ

Дорноговь, Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдээс Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 3, 7.6 дугаар зүйлийн 3-т заасны дагуу эрх бүхий албан тушаалтнаас ирүүлж буй зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, тээврийн хэрэгслийг хураах, үнийг гаргуулах албадлагын арга хэмжээ авахуулах хүсэлт, торгох шийтгэлийг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих санал болон шийтгэлийг албадан гүйцэтгүүлэхтэй холбоотой асуудлыг Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэх нь тус шүүхийн зорилго, чиг үүрэг, хяналтын хэлбэртэй нийцэж байгаа эсэхэд эргэлзээтэй, холбогдох ажиллагааг хэрэгжүүлэх журам, харьяалал тодорхойгүй байгааг анхаарч, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай талаар санал ирүүлсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2-т “Захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27, 6.28, 6.31, 6.33, 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60, 6.61, 6.64, 6.65, 6.66 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэнэ” гэж, 7.3 дугаар зүйлийн 3-т “Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 4.4 дүгээр зүйлд заасан албадлагын арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг шийтгэл оногдуулсан шийдвэр гаргаснаас хойш 24 цагийн дотор энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд гаргана” гэж, 7.7 дугаар зүйлийн 2-т “Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн ... заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ” гэж тус тус заажээ.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8-д “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа (оршин байгаа) газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана” гэж заасан байна.

Эдгээр хуулийн зохицуулалтуудын дагуу захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх зөрчилд “шийтгэл оногдуулсан” болон “шийтгэлээс чөлөөлсөн” шийдвэрийг эс зөвшөөрвөл оролцогч гомдол, прокурор дүгнэлт гаргаж

тус шүүхэд хандсанаар захиргааны хэргийн шүүх зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэдэг бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8-д заасны дагуу зөрчилд шийтгэл оногдуулсан эрх бүхий этгээд буюу улсын байцаагчаас "зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах"-аар захиргааны хэргийн шүүхэд хүсэлт гаргаж, улмаар захиргааны хэргийн шүүхээс зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгслийг хураах эсэхийг, улсын орлого болгох эсэхийг шийдвэрлэж байна.

Мөн захиргааны байгууллага, албан тушаалтнаас өөрийн гаргасан шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр захиргааны шүүхэд хандах, торгох шийтгэлийг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих, эсхүл нэмэгдүүлсэн төлбөр нэмж тооцсоныг шүүхээр баталгаажуулах хүсэлт гаргах тохиолдол байдаг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж, 3 дугаар зүйлийн 3.1.3-т "... "нэхэмжлэл" гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг (ойлгохоор)", 3.1.11-д "... "гомдол" гэж хуульд тусгайлан зааснаар эрх бүхий этгээдийн шийдвэрийг хянуулахаар захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдөл, шүүгчийн захирамж, тогтоол, анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хянуулахаар гаргасан өргөдөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг /ойлгохоор/" тус тус зааснаас үзэхэд захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа, шийдвэрийн улмаас хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд шүүхийн журмаар сэргээх үндсэн зорилготой, энэ зорилгын үүднээс хүн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэл, гомдлоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг шүүх юм.

Гэтэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дээрх заалтуудаар захиргааны байгууллага, албан тушаалтны хүсэлтээр хүн, хуулийн этгээдийн эрхэд халдсан шийдвэрийг захиргааны хэргийн шүүх гаргаж болохоор зохицуулалтыг хуульчилсан нь захиргааны хэргийн шүүхийн үндсэн зорилгод нийцэхгүй, захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг баталгаажуулах буюу дээд шатны захиргааны байгууллагын шинжтэй чиг үүргийг гүйцэтгэхээр болсон нь шүүх хөндлөнгийн, хараат бус байх зарчмыг алдагдуулахад хүргэж байна.

Аливаа иргэн, хуулийн этгээд нь захиргааны байгууллагын шийдвэр, шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрвөл захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах замаар эрхээ хамгаалах ба хэрэв захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол хүлээн зөвшөөрсөнд тооцож, захиргаа гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг өөрөө хангах талаар Захиргааны ерөнхий хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1.1-д "Захиргааны шийдвэрийг (захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага) гүйцэтгэнэ" гэж заасан байхад хүчин төгөлдөр болсон захиргааны шийдвэрийн биелэлтийг захиргааны хэргийн шүүх хангах агуулгатай дээрх зохицуулалтууд нь Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна.

Тодруулбал, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүчин төгөлдөр болсон шийдвэр, түүний үр дагаврыг захиргааны хэргийн шүүх эрх бүхий этгээд болох улсын байцаагчийн хүсэлтээр шийдвэрлэх хууль зүйн үндэслэлгүй.

Зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгслийн өмчлөгч хэн болох, уг тээврийн хэрэгсэл амьжиргааны эх үүсвэр мөн эсэхийг, торгох шийтгэлийг өөр шийтгэлээр солих эсэх, нэмэгдүүлсэн төлбөр нэмж тооцох эсэх нь захиргааны хэргийн маргаан биш юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7-д "Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах нийгмийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг дангаар батална", 15.7.1-д "эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцаа" гэж, 20 дугаар зүйлийн 20.8-д "Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг эцэслэн хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно" гэж тус тусааснаар Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дээрх заалтуудын хэрэгжилт, үр дагаварт үнэлгээ хийж, бусад хууль болон хууль зүйн бодлогод нийцэж байгаа эсэхэд хяналт тавихаар байна.

Мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ" гэж заасаар холбогдох ажиллагааг хийх зайлшгүй шаардлагатай байна.

Иймд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дээрх зүйл заалтуудад хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ хийж, уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуулийн хийдэл, зөрчлийг арилгуулах, Засгийн газраас хууль санаачлах асуудлыг шийдвэрлүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд санал хүргүүлэх нь зүйтэй гэж тогтов.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААН